



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 12

Хажуу шинэ ус

Г Малын тоо толгойн албан татварын  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 д, 18.2, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, Захиргааны ерөнхий хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нэг малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:

- А.Хонь 400 төгрөг
- Б. Ямаа 500 төгрөг
- В.Үхэр 2000 төгрөг
- Г. Адуу 2000 төгрөг
- Д.Тэмээ 2000 төгрөг

2. Малын тоо толгойн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэхийг сумын Засаг дарга (Ө. Мөнх-Амгалан)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА



С ДУГАРБААТАР

4801190047